



Орхонгэ тутмын хэвлэл
ны 06 дугаар сарын 07
№21 /642/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Мангал Улсын
хууль

714

Мангал Улсын Их
Хурлын тогтоол

715

Мангал Улсын Дээд
шүүхийн тогтоол

724

**Зээлийн болон санхүүжилтийн
хэлэлцээр соёрхон батлах
тухай**

**Зэсийн баяжмал хайлуулах,
боловсруулах үйлдвэр
байгуулах тухай**

**Төрийн албаны тухай
хуулийн зарим зүйл, заалтыг
тайлбарлах тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- | | | |
|------|--|-----|
| 167. | Зээлийн болон санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай | 714 |
| 168. | Хэлэлцээр соёрхон батлах тухай | 714 |
| 169. | Хэлэлцээр соёрхон батлах тухай | 714 |
| 170. | Зээлийн гэрээг соёрхон батлах тухай | 715 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 171. | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах тухай | Дугаар 21 | 715 |
| 172. | Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 02 дугаар дүгэмэлтийн тухай | Дугаар 22 | 716 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 173. | Эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлаархи стратегийн баримт бичгийн тухай | Дугаар 63 | 717 |
| 174. | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай | Дугаар 64 | 718 |
| 175. | Тогтоол болон журамд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 65 | 724 |

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 176. | Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай | Дугаар 08 | 724 |
|------|--|-----------|-----|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Монголын ипотекийн зах зээлийг хөхиүлэн дэмжих" төслийн Зээлийн болон Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хоорондын "Санхүүгийн хамтын ажиллагааны Ерөнхий хөтөлбөр" байгуулах тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хоорондын "Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл-нэмэлт"-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сан хооронд 2010 оны 3 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан "Уньт-Мөрөнгийн чиглэлд Уньт-Тариалангийн хооронд авто зам барих төслийг хэрэгжүүлэх тухай зээлийн гэрээ"-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах тухай

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд дараахь арга хэмжээ авахыг Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

1/зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах оновчтой хувилбарыг сонгон, саналаа Улсын Их Хуралд 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулах;

2/энэ тогтоолын 1 дэх заалтын 1-д заасан оновчтой хувилбарыг сонгохдоо хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсын хэмжээнд хэрэглэгддэг орчин үеийн технологийг сонгох;

3/зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх



үүсвэрийг бүрдүүлэх арга, хэлбэрийг тодорхойлох.

4/зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг 2011 оны эхний хагас жилд багтаан хангах.

2 Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо ЛЦ Баярсайхан/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад "Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна.", 32.1.9 дэх заалтад "Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.", 32.2.1 дэх заалтад "Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна.", мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт "Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.",

Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэц түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

**Эрүүл мэндийн санхүүжилтийн
асуудлаархи стратегийн баримт
бичгийн тухай**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй нягт уялдуулан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь.

1. Эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлаархи стратегийн баримт бичгийг сайшваасугай.

2. Эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлаархи стратегийн баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

3. Эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлаархи стратегийн



баримт бичигт тусгасан зорилт болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

**Газрыг улсын тусгай хэрэгцээнд
авах тухай**

Газрын тухай хуулийн 18.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Рашаант сум, Төв аймгийн Өндөрширээт сумын нутаг дэвсгэрт 34140 га газар, Өвөрхангай аймгийн Бүрд, Баян-Өндөр сум, Төв аймгийн Дэлгэрхаан, Эрдэнэсант сумын нутаг дэвсгэрт 37917 га газрыг Төвийн бүсийн аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд тус тус авч, хилийн заагийг хавсралт ёсоор баталсугай.

2. Төвийн бүсийн аймаг дундын отрын бүс нутгийг хариуцсан ажилтан ажиллуулах, бэлчээрийг хашиж хамгаалах, малын хашаа, тэжээлийн агуулах барих, өвс, тэжээлийн нөөц бий болгох, бэлчээр усжуулахад шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАТТУЛГА

**ТӨВИЙН БҮСИЙН АЙМАГ ДУНДЫН ОТРЫН
БЭЛЧЭЭРИЙН ХИЛИЙН ЗААГ**

Нэг. Аймаг дундын "Чилэн"-гийн отрын бэлчээрийн
хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбилцол

| Цэгийн дугаар | Газрын нэр | Уртраг | Өргөрөг |
|---|----------------------|-----------------|----------------|
| 1. Булган аймгийн Баяннуур сум /2988.0 га/ | | | |
| 1.1 | Хөх өндөр уул | 104° 38' 0.41" | 47° 40' 57.28" |
| 1.2 | Сант уул | 104° 41' 31.34" | 47° 41' 21.79" |
| 1.3 | 1491.2 тоот | 104° 43' 23.93" | 47° 40' 59.99" |
| 1.4 | Ганц худаг | 104° 42' 56.69" | 47° 39' 49.45" |
| 1.5 | Дэлгэрхаан уул | 104° 36' 12.36" | 47° 39' 58.85" |
| 1.6 | Овоот уул | 104° 33' 12.37" | 47° 40' 08.02" |
| 1.7 | Хөшөөт уул | 104° 32' 58.15" | 47° 39' 28.67" |
| 1.8 | Элст худаг | 104° 31' 33.25" | 47° 38' 02.75" |
| 1.9 | Хурлын ухаа | 104° 30' 17.97" | 47° 37' 07.87" |
| 1.10 | Далын голын төгөл | 104° 30' 0.89" | 47° 38' 47.66" |
| 2. Булган аймгийн Дашинчилэн сум /19245.0 га/ | | | |
| 2.1 | Их өрхтий | 103° 57' 33.10" | 47° 36' 14.23" |
| 2.2 | Өлийн даваа | 103° 59' 51.76" | 47° 35' 27.40" |
| 2.3 | 1524.0 тоот өндөрлөг | 104° 01' 25.85" | 47° 35' 05.56" |
| 2.4 | Бага өрхтий | 104° 01' 33.01" | 47° 34' 16.88" |



| | | | |
|--|--|-----------------|-----------------|
| 2.5 | Бор толгой | 104° 05' 12.68" | 47° 33' 37.96" |
| 2.6 | Хомгор уул | 104° 06' 38.52" | 47° 34' 24.43" |
| 2.7 | Дунд ухаа | 104° 11' 49.56" | 47° 35' 46.04" |
| 2.8 | 1348.0 тоот өндөрлөг | 104° 12' 50.35" | 47° 36' 03.75" |
| 2.9 | Сэртэн уул | 104° 18' 50.86" | 47° 38' 40.55 " |
| 2.10 | Цахирын цагаан толгой | 104° 24' 0.21" | 47° 38' 20.25" |
| 2.11 | Далын голын төгөл | 104° 30' 0.89" | 47° 38' 47.66" |
| 2.12 | Хурлын ухаа | 104° 30' 17.79" | 47° 37' 07.87" |
| 2.13 | Цахирын цагаан нуур | 104° 25' 04.12" | 47° 37' 01.51" |
| 2.14 | Дашинчилэн овоот уул | 104° 20' 42.76" | 47° 36' 40.62" |
| 2.15 | 1381.5 тоот өндөрлөг | 104° 18' 26.44" | 47° 36' 42.67" |
| 2.16 | Бага хорго уул | 104° 06' 45.24" | 47° 30' 40.09" |
| 2.17 | Баянгуур, Дашинчилэнгийн хилийн зааг | 104° 02' 15.00" | 47° 30' 36.78" |
| 3. Булган аймгийн Рашаант сум /4756.0 га/ | | | |
| 3.1 | Шар толгой | 103° 52' 28.17" | 47° 32' 06.73" |
| 3.2 | 1120.0 тоот өндөрлөг | 103° 54' 29.60" | 47° 36' 24.79" |
| 4. Төв аймгийн Өндөрширээт сум /7151.0 га/ | | | |
| 4.1 | Элст худаг | 104° 31' 33.25" | 47° 38' 02.75" |
| 4.2 | Хөшөөт уул | 104° 32' 58.15" | 47° 39' 28.67" |
| 4.3 | Овоот уул | 104° 33' 12.37" | 47° 40' 08.02" |



| | | | |
|-----|----------------------|-----------------|----------------|
| 4.4 | Далгэрхаан уул | 104° 36' 12.36" | 47° 39' 58.85" |
| 4.5 | Ганц худаг | 104° 42' 56.69" | 47° 39' 49.45" |
| 4.6 | Эхэн өндөр уул | 104° 42' 39.01" | 47° 38' 22.47" |
| 4.7 | Бүсийн цагаан толгой | 104° 38' 48.90" | 47° 36' 30.53" |
| 4.8 | Бор толгой | 104° 33' 33.46" | 47° 37' 09.51" |
| 4.9 | Хурлын ухаа | 104° 30' 17.97" | 47° 37' 07.87" |

Хоёр. Аймаг дундын "Хөх дэл"-ийн отрын бэлчээрийн хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбилцол

5. Өвөрхангай аймгийн Бүрд сум /9432.0 га/

| | | | |
|-----|------------------------------------|-----------------|----------------|
| 5.1 | - | 104° 08' 00.0" | 46° 53' 00.0" |
| 5.2 | Тасархай толгой /1829.5 тоот/ | 104° 15' 18.45" | 46° 58' 06.85" |
| 5.3 | Хөх дэл уул /2032.6 тоот/ | 104° 20' 02.76" | 46° 57' 57.81" |
| 5.4 | Мөнгөн овоот толгой /1846.5 тоот/ | 104° 18' 51.97" | 46° 55' 31.55" |
| 5.5 | Замбалын хар уул /1964.1 тоот/ | 104° 14' 18.19" | 46° 53' 39.77" |
| 5.6 | Бүрд, Баян-Өндөр сумын хилийн зааг | 104° 08' 00.0" | 46° 54' 03.82" |

6 Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум /10850.0 га/

| | | | |
|-----|------------------------------------|-----------------|----------------|
| 6.1 | Бүрд, Баян-Өндөр сумын хилийн зааг | 104° 08' 00.0" | 46° 54' 03.82" |
| 6.2 | Замбалын хар уул /1946.1 тоот/ | 104° 14' 18.19" | 46° 53' 39.77" |
| 6.3 | Баруун ямаатын хяр-1 | 104° 14' 19.90" | 46° 53' 10.01" |



| | | | |
|---|--------------------------------------|-----------------|----------------|
| 6.4 | Баруун ямаатын хяр-2 | 104° 16' 37.68" | 46° 51' 18.56" |
| 6.5 | Хужиртын хэрсэн толгой /1695.4 тоот/ | 104° 17' 24.72" | 46° 48' 49.18" |
| 6.6 | Давст нуур | 104° 15' 19.68" | 46° 48' 32.51" |
| 6.7 | Сувраа уул /1939 тоот/ | 104° 10' 48.01" | 46° 49' 29.66" |
| 6.8 | Хар овоот уул /1797 тоот/ | 104° 06' 16.87" | 46° 49' 37.01" |
| 6.9 | 1599.1 тоот өндөрлөг | 104° 04' 10.79" | 46° 51' 18.82" |
| 6.10 | - | 104° 08' 00.0" | 46° 57' 00.0" |
| 7. Төв аймгийн Дэлгэрхаан сум /6423.0 га/ | | | |
| 7.1 | Хужиртын Хэрсэн толгой | 104°17' 24.72" | 46° 48' 49.18" |
| 7.2 | Баруун ямаатын хяр-2 | 104° 16' 37.68" | 46° 51' 18.56" |
| 7.3 | Баруун ямаатын хяр-1 | 104° 14' 19.90" | 46° 53' 10.01" |
| 7.4 | Замбалын хар уул /1946.1 тоот/ | 104° 14' 18.19" | 46° 53' 39.77" |
| 7.5 | Мөнгөн овоот толгой /1846.5 тоот/ | 104° 18' 51.97" | 46° 55' 31.55" |
| 7.6 | Хөх дэл уул /2032.6 тоот/ | 104° 20' 02.76" | 46° 57' 57.81" |
| 7.7 | - | 104° 20' 45.07" | 46° 57' 35.85" |
| 7.8 | - | 104° 22' 58.05" | 46° 57' 20.41" |
| 7.9 | Их угалзын ар | 104° 21' 36.46" | 46° 55' 25.94" |
| 7.10 | Ар уртын булаг | 104° 20' 03.41" | 46° 54' 27.93" |
| 7.11 | Зүүн ямаат уул | 104° 19' 0.03" | 46° 53' 28.06" |



| | | | |
|--|--------------------|-----------------|----------------|
| 7.12 | Холбоо уул | 104° 19' 41.83" | 46° 51' 03.28" |
| 7.13 | Хааны цагаан хөтөл | 104° 18' 45.13" | 46° 49' 39.56" |
| 8. Төв аймгийн Эрдэнэсант сум /11212.0 га/ | | | |
| 8.1 | Хөх дэл уул | 104° 20' 02.76" | 46° 57' 57.81" |
| 8.2 | Дуулагт уул | 104° 20' 34.58" | 46° 59' 25.58" |
| 8.3 | Шарга уул | 104° 21' 55.05" | 47° 02' 45.19" |
| 8.4 | Өндөр толгой | 104° 23' 32.50" | 47° 02' 27.23" |
| 8.5 | Залаа толгой | 104° 25' 39.23" | 47° 02' 32.44" |
| 8.6 | 1628.9 тоот | 104° 28' 0.42" | 47° 02' 13.15" |
| 8.7 | 1465.0 тоот | 104° 31' 43.24" | 47° 02' 35.43" |
| 8.8 | 1525.2 тоот | 104° 32' 08.43" | 47° 02' 18.37" |
| 8.9 | Өндөр сант уул | 104° 32' 07.63" | 47° 00' 13.20" |
| 8.10 | Цагаан уул | 104° 30' 41.25" | 46° 59' 03.67" |
| 8.11 | Хар чулуут уул | 104° 28' 08.19" | 46° 58' 35.43" |
| 8.12 | - | 104° 26' 49.39" | 46° 58' 17.70" |
| 8.13 | - | 104° 26' 28.94" | 46° 57' 54.75" |
| 8.14 | - | 104° 25' 24.30" | 46° 57' 22.16" |
| 8.15 | - | 104° 23' 46.83" | 46° 57' 36.43" |
| 8.16 | - | 104° 22' 58.05" | 46° 57' 20.41" |
| 8.17 | - | 104° 20' 45.07" | 46° 57' 35.85" |



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

Тогтоол болон журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцаар хангах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 321 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн "арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцыг м2 талбайн үнийг 650.0 (зургаан зуун тавин) мянган төгрөгөөс хямд байх (нийслэлд) зарчим баримтлан" гэснийг "орон сууцыг" гэж өөрчилсүгэй.

2. "Журам батлах тухай" Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 388 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах журам"-ын 2.1-д "арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа" гэснийг "ашиглалтад орсон шинэ" гэж, 5.1-д "арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа" гэснийг "ашиглалтад орсон" гэж тус тус өөрчлөн, мөн журмын 5.3 дахь хэсгийг хүчингүй болгонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД

Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:



1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсоноос хойш сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон этгээдэд хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт нэгэн адил хамаарна.

Энэ хэсэгт заасан "...**орон тооны албан тушаал**..." гэдгийг аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагын бүтцэд багтдаг, цалин хөлстэй, тодорхой чиг үүрэг бүхий, байнгын шинжтэй ажлын байр гэж ойлгоно.

2. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.14-т заасан "...**аливаа хэлбэр**..."-т сонгуулийн сурталчилгааны бүхий л үйл ажиллагааг хамааруулж үзнэ.

3. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3-т заасан "... **албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах**..." гэж хууль тогтоомж болон эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, эсхүл ажлын байрны тодорхойлолтод зааснаар тухайн албан тушаалтны удирдлагын дор үүрэг гүйцэтгэх, түүнд ажлын гүйцэтгэлээ хянуулж, дүгнүүлэхийг хэлнэ.

Мөн хэсэгт заасан "...**гэр бүл**...", "...**төрөл, садан**..." гэдгийг "Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2006 оны 33 дугаар тогтоолын 10-т зааснаар ойлгож хэрэглэнэ.

4. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан "...**сул орон тоо гарсан**..." гэж хуулийн 23, 24, 25 дугаар зүйл, 26 дугаар зүйлийн 26.1.3-т заасан үндэслэлээр төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан болон төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын ажлын байр суларсан байхыг хэлнэ.

Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 17 дугаар зүйлийн 17.3-т заасан төрийн албанд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаагүй этгээд тухайн албан тушаалд ажиллаж байгааг "**сул орон тоо гарсан**" гэдэгт хамааруулж үзнэ.

Мөн хэсэгт заасан "...**сонгон шалгаруулах**..." гэж төрийн жинхэнэ албан хаагчдын дотроос үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан, өрсөлдүүлэн судалж, тэдгээрийн дотроос тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хамгийн илүү хангаж байгааг нь тодруулахыг ойлгоно.

Ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас сонгон шалгаруулж, албан тушаалын сул орон тоог нөхөх эрх нь зөвхөн тухайн албан тушаалтныг томилох эрх бүхий этгээдэд хамааралтайг анхаарвал зохино.

5. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан "...**эзгүй байгаа албан хаагч**..." гэдэгт хууль тогтоомжид заасны дагуу ээлжийн амралт эдлэж байгаа, эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөө авсан, албан томилолтоор ажилласан, түр хугацаагаар сургалтад хамрагдсан, эдгээртэй адилтгах бусад шалтгааны улмаас албан үүргээ түр хугацаагаар гүйцэтгээгүй этгээд хамаарна.



Хуульд заасан үндэслэлээр ажлын байрны сул орон тоо гарсныг **"ээгүй байгаа албан хаагч"-д** хамааруулж үзэхгүй.

6. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасан **"... зөвшөөрсөн ..."** гэдгийг албан тушаалтны шахалт шаардлага, зүй бус нөлөөлөл зэрэг хөндлөнгийн оролцоогүй, төрийн албан хаагчийн өөрийнх нь хүсэл зоригийн илэрхийлэл гэж ойлгох бөгөөд зөвшөөрөл нь бичгийн хэлбэртэй байна.

Мөн хэсэгт заасан **"...сэлгэн ажиллуулж..."** гэдгийг албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээг бууруулахгүйгээр ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заасантай адил төрлийн чиг үүрэг бүхий албан тушаалд шилжүүлж томилох гэж ойлгоно.

7. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасан **"...хангалтгүй биелүүлсэн..."** гэдгийг ажлын байрны тодорхойлолт болон албаны чиг үүрэгт тусгагдсан, хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааг гүйцэтгэсэн боловч чанарын хувьд доголдуулсан, хугацаа хэтрүүлсэн, тогтоосон журмыг зөрчсөн зэргээр зохих ёсоор биелүүлээгүй байхыг ойлгоно.

Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан **"...албан үүргээ биелүүлээгүй..."** гэж хууль тогтоомжид болон ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг гүйцэтгээгүй, хэрэгжүүлээгүй байхыг хэлнэ.

8. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасан **"үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь төрийн тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон"** гэдэгт хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн албаны төв байгууллагаас тогтоосон төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт)-г үнэлэх журамд заасны дагуу дүгнэсэн үнэлгээгээр хангалтгүй дүн авсныг ойлгоно.

9. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.1.2-т заасан **"тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн", "төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн"** эсэхийг төрийн жинхэнэ албан хаагчийн иргэний үнэмлэх дээр бичигдсэн он, сар, өдрөөр тодорхойлно.

10. Мөн зүйлийн 24.1.3-т заасан **"өөрийн санаачилгаар... хүсэлт гаргасан"** гэснийг "Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2006 оны 33 дугаар тогтоолын 14-т зааснаар ойлгоно.

11. Хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т заасан 1 сарын хугацааг сахилгын зөрчил гаргасныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан олж мэдсэн үеэс эхлэн тоолно.

Энэ хэсэгт заасан **"...зөрчил гаргаснаас хойш 6 сар өнгөрсөн..."** гэдэгт зөрчил гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор уг зөрчил илрээгүй, мэдэгдээгүй өнгөрсөн байхыг ойлгоно.

12. Мөн зүйлийн 26.6-д заасан **"... сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс нэг жилийн дотор..."** гэж сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс хойш



хуанлийн нэг жил бүтэн өнгөрснийг хэлнэ.

13. Эрх бүхий албан тушаалтан мөн зүйлийн 26.1-д заасан сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийн талаар холбогдох этгээдэд заавал мэдэгдэж, баримтжуулах бөгөөд ийнхүү мэдэгдсэн хугацаанаас хойш энэ зүйлийн 26.8-д заасан хугацааг тоолно.

14. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.10-т заасан **"гэр бүлээс нь их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн 1 хүүхэд..."** гэдэгт төрийн албан тушаал эрхэлж байгаа иргэний төрсөн буюу үрчилж авсан хүүхдүүдээс боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан өмчийн аль ч хэлбэрийн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуульд элсэн суралцах эрхийг тогтоосон журмын дагуу олж авсан зөвхөн нэг хүүхэд хамаарна.

15. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3-т заасан **"төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан ..."** гэж Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулагдсаныг хэлнэ.

Энэ хэсэгт заасан **"...зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн..."** гэдэгт эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц /алба, тасаг, хэлтэс, газар тэдгээртэй адилтгах бусад нэгж/-ийг шинээр бий болгосныг ойлгоно.

Мөн хэсэгт заасан **"...төрийн албан хаагчийн албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн..."** гэж өөрчлөн байгуулагдсан бүтцийн нэгжид тухайн албан тушаалтны албан тушаалын нэр өөрчлөгдсөн боловч хэрэгжүүлэх чиг үүрэг нь өөрчлөгдөөгүй, хасагдсан эсхүл нэмэгдсэн, түүнчлэн томъёоллын хувьд өөрчлөгдсөн ч өмнөх агуулга нь хэвээр байхыг хэлнэ.

Энэ хэсэгт заасан **"...орон тоо цөөрсөн..."**, мөн зүйлийн 27.2.4-т заасан **"...орон тоо хасагдсан ..."** гэдгийг "Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2006 оны 33 дугаар тогтоолын 15.1.1, 15.1.2-т зааснаар тус тус ойлгоно.

Мөн хэсэгт заасан **"...шалгаруулж авна"** гэж эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилогдсон бүрэлдэхүүн, ажлын хэсэг /комисси-ийн дүгнэлтийг үндэслэн ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа ажилтныг сонгохыг хэлнэ.

16. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.4-т заасан **"төрийн байгууллага татан буугдсан..."** гэдгийг Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасны дагуу ойлгоно.

Төрийн байгууллага татан буугдсаныг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан журмын дагуу бүртгэнэ.

17. Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-т заасан **"...биеэр эдэлж чадаагүй..."** гэдэгт албан ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа огт эдлээгүй, эсвэл ээлжийн амралттай байх үедээ байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр дуудагдан ажиллаж, нөхөн амраагүй зэргийг хамааруулж үзнэ.

18. Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д заасан **"...хүний нөөцийн**



удирдлагатай холбогдон гарсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр...”-т төрийн жинхэнэ албанд нэр дэвшигч болон төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалд сонгон шалгаруулж нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, дэвшүүлэх, үр дүнгийн гэрээ байгуулах, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, зэрэг дэв олгох, сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зэрэг хүний нөөцөд холбогдох асуудлаар гаргасан эрх зүйн актууд хамаарна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т “Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл сум, дүүргийн Засаг даргын захирамжийг аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжийг Ерөнхий сайд тус тус өөрчлөх буюу хүчингүй болгоно” гэж заасан нь хүний нөөцийн удирдлагатай холбогдсон асуудлаар гарсан шийдвэрт хамаарахгүй.

19. Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д заасан асуудлаар гаргасан Төрийн албаны төв байгууллагын шийдвэрт зөвхөн маргаан бүхий асуудалтай холбогдох төрийн жинхэнэ албан хаагч гомдол гаргах эрхтэй.

20. Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь заалтыг дараах байдлаар ойлгож хэрэгжүүлнэ:

20.1 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан журмын дагуу гаргасан гомдлыг Төрийн албаны төв байгууллага урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянах бөгөөд мөн хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шийдвэрийнхээ хувьд шүүхэд хариуцагч болохгүй.

20.2 Энэ зүйл, хэсэгт заасан 30 хоногийн хугацааг шийдвэр гарсан талаар холбогдох этгээд мэдсэн үеэс эхэлж тоолно. Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ талаар холбогдох этгээдэд мэдэгдэж, энэ талаар баримтжуулсан байвал зохино.

21. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 1995 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 245, 1996 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 153, 2005 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 21 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧИД**

**С.БАТДЭЛГЭР
Л.АТАРЦЭЦЭГ
Ц.СУМЪЯА**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1

Нислэг: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэл хэргийн хэвлэл,
Утас 329487